



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 04

Мөрөн сум

Орон нутгийн өмчид хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дүгээр зүйлийн 35.1.11, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 413, 414 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXI хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон 5 нэрийн 5,170,301,94С (таван тэрбум нэг зуун далан сая гурван зуун нэг мянга есөн зуун дөчин ес) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг эзэмших байгууллагыг хавсралтаар баталсугай.

2.Хөрөнгө эзэмших байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, "төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу үндсэн хөрөнгийн холбогдох дансанд бүртгэж, 2023 оны дөрөвдүгээр улирлын тайланд тусгах.

3.Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Г.МӨНГӨНХУЯГ



8712082112

Аймгийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн ээлжит XXI
хуралдааны 09 дугаар
тогтоолын хавсралт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон орон нутгийн өмчид бүртгэх барилга байгууламжийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Барилга байгууламжийн хүчин чадал, байршил	Ашиглалтад орсон но	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх дүн	Бүртгэх шалгаан	Гүйцэтгэгч байгууллага	Эзэмших байгууллага
1	Эрүүл мэндийн төвийн барилга /иж бүрдэл/	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, 20 ортой, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 25м*14.8м	2023-02-28	м.кв	370	2 260 100 000,00	ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 413 дугаар тогтоол	"Ювоку" ХХК	Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв
2	Уурын зуухны барилга	Тэнхлэгээрээ 6м*6м, 1 давхар, зоорийн давхаргүй	2023-02-28	м.кв	36		ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 413 дугаар тогтоол	"Ювоку" ХХК	Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв
3	Цогцос хадгалах байр	Тэнхлэгээрээ 10.8м*6м, 1 давхар, зоорьгүй	2023-02-28	м.кв	64,8		ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 413 дугаар тогтоол	"Ювоку" ХХК	Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв
4	Цэцэрлэгийн барилга	Баянзүрх сумын 100 ортой цэцэрлэгийн барилга	2022.09.01	м.кв		1 413 431 100,00	ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 414 дүгээр тогтоол	"Хөвсгөл Батчандмань" ХХК	Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэг
5	Цэцэрлэгийн барилга	Бүрэнтогтох сумын 150 ортой цэцэрлэгийн барилга	2022.09.26	м.кв	408	1 496 770 849,00	ТӨБЗГ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 414 дүгээр тогтоол	"Мөнх-Өргөө" ХХК	Бүрэнтогтох сумын Хүүхдийн цэцэрлэг
	Дүн					5 170 301 949,00			